

## **“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК-ИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

“Блюскай секьюритиз ҮЦК” ХК нь 2014 оны 4 дүгээр сарын 18-нд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуулийн хүрээнд хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргахаар шийдвэрлэж, үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт материалын хамт Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж байсан билээ.

Тухайн үед манай компанийн хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын томилсон ажлын хэсэг хянаж үзээд нэмж баримт материал шаардах, баримт бичгийн агуулгын талаарх олон төрлийн шаардлагыг удаа дараа тавьж, тухай бүр нь манай компаниас зохих хариултыг өгч, нэмэлт баримт материал бүрдүүлэн ажиллаж ирсэн.

Түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 200.0 сая, дилерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьд 300.0 сая төгрөг тус тус байхаар тогтоогоод байгаатай уялдуулан “Блюскай секьюритиз ҮЦК” ХК нь өөрийн үндсэн үйл ажиллагаагаа цаашид эрхлэн явуулах бололцоог хангах үүднээс хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа юм.

Бид бүхний зүгээс нэмж энгийн хувьцаа гаргах үйл ажиллагааг гүйцэтгэхдээ боломжит хөрөнгө оруулагчдыг олох, тэдгээрийн манай компанид хөрөнгө оруулах шийдвэрийг гаргуулахад асар их хүчин чармайлт гаргаж ажилласан бөгөөд үүний үр дүнд ИБУИНВУ-ын “Блю корт” Хөрөнгө оруулалтын сан, менежментийн компанитай хамтран ажиллах тохиролцоонд хүрч, зохих гэрээ хэлцлийг байгуулсан юм.

Ингээд нэмж гаргах хувьцааг бүртгүүлэхэд шаардлагатай баримт материалыг бүрэн бүрдүүлсэн бөгөөд хамгийн сүүлд “Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хурлаар зарим асуудлыг нэмж шийдвэрлэж, Санхүүгийн зохицуулах хороонд бүх баримт материалаа хүргүүлсэн билээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 243 дугаар тогтоолоор “Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн нэмж гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,805,054 ширхэг хувьцааг бүртгэсэн.

Иймд дээрх шийдвэртэй холбогдуулан тус компанийн 1,805,054 / нэг сая найман зуун таван мянга тавин дөрвөн / ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэн, тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,892,540 / нэг сая найман зуун ерөн хоёр мянга таван зуун дөч / ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсон.

Компанийн тухай хуулийн дагуу дээрх нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдаж авах, эсхүл өөрийн эзэмшиж буй хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх эрх манай хувьцаа эзэмшигчдэд үүссэн болохыг хөрөнгийн биржийн цахим хуудас, МҮОНРТТелевизээр орон даяар 4 удаагийн

давталттайгаар мэдээллэж, “Өнөөдөр”, “Үндэсний шуудан” өдөр тутмын сонины 2015 оны 5 дугаар сарын 29, 6 дугаар сарын 12-ны дугаарт нийтэлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолын дагуу мэдээлэл хүргэх ажиллагааг авч хэрэгжүүлэхэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах хүсэлтээ Э.Алтаншагай /РД: ЦЕ78101074 /, Тай Там Корпораци /Tai Tam Corporation РД: 279584 / гэх 2 хувьцаа эзэмшигч ирүүлээд байгаа бөгөөд үлдсэн хувьцааг “Блокорт” ХХН-ын охин компани болох Монгол Улсад бүртгэлтэй “Урбан ресорс” ХХК-д худалдах юм.

Хувьцаа эзэмшигч Э.Алтаншагай 227 ширхэг хувьцаа, хувьцаа эзэмшигч Тай Там Корпораци 2050 ширхэг хувьцаа, “Урбан ресорс” ХХК нийт 180,505 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 554 төгрөгөөр худалдан авахаар захиалгаа өгсөн боловч Тай Там Корпораци захиалгын гэрээгээ цуцалж 182,782 ширхэг хувьцааг “Урбан ресорс” ХХК болон хувьцаа эзэмшигч Э.Алтаншагай нарын өмчлөлд бүртгэгдсэн.

Олон нийтэд хөрөнгийн зах зээлийн талаар мэдээлэл хүргэж үнэт цаасны 1180 данс нээсэн байна

ШУТИС-ийн харьяа Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн Сургуулийн урилгаар “Хөрөнгө оруулалтын менежмент” хичээлийн хүрээнд оюутнуудад мэдээлэл хийж хамтран ажилласан.

Баянгол дүүргийн НДХэлтэсээс ажилчидаа нийгмийн даатгалд хамруулах, шимтгэл төлөлтийн талаар шалгалт хийсэн. Энэ шалгалтаар ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Монгол шуудан ХК-ны анхдагч арилжаанаас 4 харилцагчидаа хувьцаа авахад нь зуучилсан.

Олон нийтийн сүлжээг ашиглан компаний таниулж харилцагчдынхаа тоог нэмэгдүүлж байна.

Англи хэл дээр бэвсайт ажиллуулж байна.

**“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ УЦК” ХК**